

ТАНИЛЦУУЛГА

*“Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын
сургуульд суурилсан эрүүл мэндийн
урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх
үзлэгийн товлал болон зардлын
төлбөрийн хэмжээ, түүнийг санхүүжүүлэх
журам” батлах тухай ЭМДҮЗ-ийн
тогтоолын төсөл*

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэгт “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ, халдварт өвчний эсрэг дархлаажуулалтад түүний нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн тогтоосон товлосон хугацаанд хамруулан, эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь санхүүжүүлэх бөгөөд холбогдох журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Үндэсний зөвлөл батална”, 14 дүгээр зүйлийн 14.8.6-д Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь “эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар холбогдох байгууллагаас ирүүлсэн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, санал боловсруулах, эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх” эрхтэй гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны хөтөлбөрт иргэн бүрийг 2 жил тутамд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд тогтмол хамрагддаг болгож хэвшүүлэхээр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшнийг бууруулахаар, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт сургуульд суурилсан хүүхдийн эрүүл мэндийн эрт илрүүлгийн үндэсний тогтолцоог бий болгох, эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжсэн нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлж, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхээр тус тус заасан байдаг.

Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах нь эрүүл мэнд, өвчин эмгэгийн эрсдэлтэй хүнийг эрт илрүүлэн, цаашид даамжруулахгүй эмчилж, сэргийлснээр эрүүл мэндийн зардал, эмнэлгийн ачааллыг бууруулах, хүний амь нас, амьдралын чанарт ноцтой хохирол учруулж болзошгүй халдварт болон халдвар буй өвчнийг эрт үед нь илрүүлснээр үр дүнтэй эмчилж, ирээдүйд учирч болзошгүй хүндрэл, нас баралт, санхүүгийн дарамтаас сэргийлж чадахуйц ач холбогдолтой юм. Ялангуяа хүүхдэд түгээмэл тохиолддог өсөлтийн үед тулгарч буй асуудал, аутизм, зүрхний гажиг, харааны бэрхшээл зэргийг эрт үед нь илрүүлснээр эмчилгээний үр дүн сайжирч, хүүхдийн сурах үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлдэг.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 06, 2023 оны 4 болон 10 дугаар тогтоолуудын дагуу 2022 оны 6 дугаар сараас 2025 оны 9 дүгээр сар хүртэл (энэхүү хугацаанаас хойш түр зогсоосон) 4-6 насны ангиллаар давхардсан тоогоор 840.1 мянган даатгуулагчид урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдаж, эрүүл мэндийн даатгалын сангаас 113.5 тэрбум төгрөгийг санхүүжүүлсэн. Цаашид урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийг нийт хүн амд бус өвчлөлийн тархалт болон өрхөд үзүүлэх санхүүгийн нөлөөлөл, нас, хүйсийн эрсдэлд суурилсан товллол, давтамжийг илүү оновчтой хэлбэрээр зохион байгуулах нь нэн чухал байна.

Монгол Улсын Засгийн газрын “Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суурилсан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг зохион байгуулах зарим арга хэмжээний тухай” 2026 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 301 дүгээр тогтоолтой уялдуулан анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагын үзүүлсэн зарим тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх хэрэгцээ, шаардлага үүссэн. Цэцэрлэг, сургуульд суурилан хийх эрт илрүүлэг үзлэг нь хүүхдийн ирээдүйд маш чухал ач холбогдолтой. Аутизмыг эрт илрүүлснээр тархины хөгжил идэвхтэй үед нь эрчимжүүлсэн сургалтад хамруулж, нийгэмшихэд нь дэмжлэг үзүүлэх боломж бүрддэг. Зүрхний гажгийг цаг тухайд нь олж мэдвэл хүндрэл гарахаас өмнө эмчилгээ, шаардлагатай бол мэс засал хийлгэж амь насны эрсдэлийг бууруулна. Харааны асуудлыг энэ насанд засварлавал бүрэн хараатай болох боломж өндөр, харин хожимдвол эмчилгээний үр дүн, сурах чадамжид сөрөг нөлөөтэй. Биеийн ерөнхий хөгжлийг хянаснаар хоол тэжээлийн дутагдал, илүүдэл жин, өсөлтийн бэрхшээлүүдийг эрт илрүүлж хариу арга хэмжээ авах боломж бүрдэнэ.

Иймд анхан шатлалын эрүүл мэндийн байгууллага болон цэцэрлэг, сургуулийг түшиглэн бага зардлаар өндөр үр дүн, хамралт бүхий хүүхдийн зонхилон тохиолдох өвчлөлийн эрт илрүүлэг үзлэгийг санхүүжүүлэх харилцааг зохицуулсан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын төслийг боловсруулан санал авахаар байршуулав.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

--oOo--